



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны сайд Л.Болдод даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Гадаад харилцааны сайд

Н.АЛТАНХУЯГ

Л.БОЛД

Засгийн газрын 2012 оны 97 дугаар  
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСАД СУУГАА ГАДААД УЛСЫН ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
БУЮУ КОНСУЛЫН ГАЗАР, НҮБ, ТҮҮНИЙ ТӨРӨЛЖСӨН БАЙГУУЛЛАГЫН  
СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР, ГАДААД УЛС, ОЛОН УЛСЫН  
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАРТ АЖИЛЛАХ  
ГАДААДЫН ИРГЭНИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.1-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг (цаашид "гадаадын иргэн" гэх) бүртгэх, бүртгэлээс хасах, Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох, хугацааг нь сунгах, өөрчлөх, хүчингүй болгох үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенц, Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенц, Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхдээ тухайн гадаад улстай хэрэгжүүлж байгаа хоёр талын харилцаан дахь харилцан адил байх зарчмыг баримтална.

1.4. Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам"-ын 13.6.1 болон энэ журмын 2.1-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнд Монгол Улсад оршин суух А-1 үнэмлэх олгоно.

1.5. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудын суурин төлөөлөгчийн газар (цаашид "төлөөлөгчийн газар" гэх)-т ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг бүртгэх, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох үйл ажиллагааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дипломат ёслолын асуудал эрхэлсэн нэгж гүйцэтгэнэ.

1.6. Гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газар (цаашид "төлөөлөгчийн газар" гэх)-т ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг бүртгэх, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох үйл ажиллагааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэл, гадаад сурталчилгааны асуудал эрхэлсэн нэгж гүйцэтгэнэ.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэ журам нь дор дурдсан гадаадын иргэн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүнд үйлчилнэ:

- а. Элчин сайд, түр хамаарагч;
- б. Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын суурин төлөөлөгч;

